



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/62

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оныг “Бүтээмж-Хамтын ажиллагааг дээшлүүлэх” жил болгон зарласантай холбогдуулан Нийслэлийн Багахангай дүүргийн хороодын ажилд дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, “Ажлын удирдамж”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2.Ажлын хэсгийг холбогдох хууль, журам, удирдамжийн дагуу зохион байгуулан холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Ажлын хэсэг (Б.Отгонжаргал)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД


Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 04 сарын 09-ны өдрийн 116 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга: Гишүүд:	Б.Отгонжаргал	Төрийн захиргааны удирдлагын хэлтийн дарга
	Б.Цогжавхлан	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
	Б.Гэрэлцолмон	Гадаад харилцаа өргөдөл, гомдол хариуцсан ахлах мэргэжилтэн
	Н.Батцэнгэл	Эрх зүй, хяналт-шинжилгээ, үнэлгээ, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн
	А.Золзаяа	Хүний нөөц, төрийн албан хаагчийн ёс зүй, шагнал хариуцсан мэргэжилтэн
	Б.Одбаяр	Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн
	Н.Өлзийцэцэг	Архив, албан хэрэг хөтлөлт түүний зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
	Ё.Гэрэлцэцэг	Худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл хариуцсан ахлах мэргэжилтэн
	Г.Одонбаатар	Хөрөнгө оруулалт, орон нутгийн өмч, сургалт тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн
	Н.Батболд	Мэдээлэл технологи хариуцсан ажилтан
Нарийн бичиг:	Д.Оюунбаатар	Захиргааны зохион байгуулалт, гүйцэтгэлийн төлөвлөгөө, хороо хариуцсан мэргэжилтэн

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 04 сарын 09-ны өдрийн 1162 дугаар
захирамжийн хоёдугаар хавсралт



**НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ХОРООДЫН АЖИЛД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, ЗӨВЛӨН
ТУСЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр

Багахангай дүүрэг

НЭГ. ЗӨВЛӨН ТУСЛАХ АЖЛЫН ЗОРИЛГО:

Хороодод хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, түүний явц, үр дүнд хяналт тавих, хороодын ажилд дэмжлэг үзүүлэн, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, заавар зөвлөгөө өгөхөд оршино.

ХОЁР. ХУГАЦАА

Зөвлөн туслах ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулна.

ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ

Дүүргийн 1, 2 дугаар хороод

ДӨРӨВ. АЖЛЫН ЧИГЛЭЛ :

- Захирамжлалын баримт бичгийн үндэслэл агуулгад хяналт тавих
- Засгийн газрын 206 дугаар тогтоолын дагуу хяналт, үнэлгээ шинжилгээ хийж буй эсэх
- "Эрх зүйн хөтөч"-ийн хүрээнд зохион байгуулсан ажил арга хэмжээ
- Баримт бичгийн стандарт, архив, албан хэрэг хөтлөлтийн хууль, тогтоомжийн хэрэгжилт цаасан суурьт архивын баримтын нөхөн баяжилтыг бүрдүүлсэн байдал
- Өргөдөл, гомдол шийдвэрлэлт
- Хотын хөгжлийн индекс
- Нийгмийн салбарын тоо мэдээлэл
- Хамтарсан багийн үйл ажиллагаа болон амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлын талаарх мэдээ мэдээлэл
- Орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгын талаарх мэдээлэл
- Хороодын тохижилт, олон нийтийн байцаагч нар тухай онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, биелэлтийг архив бичиг хэргийн стандарт мөрдөн ажиллах

- Нийтийг хамарсан ажлын талаарх илтгэх хуудас, холбогдох баримт бичгийг үнэн зөв, бодитой гаргах
- Худалдаа үйлчилгээ, үйлдвэрийн нарийвчилсан судалгаа, хамтран ажилласан байдал
- Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн мэдээ
- Нөөцийн махны худалдааны мэдээ
- Худалдаа, үйлчилгээний байгууллагуудын гадна хаяг, өнгө үзэмжийг сайжруулсан эсэх
- Хороодын интернэт, сүлжээ техник хэрэгслийн хэвийн ажиллаагаатай танилцах
- ERP-системийн хүний нөөцийн дэд цэсийн ашиглалт болон албан хаагчдын цаг ашиглалтын талаар
- Бодлогын бичиг баримт, тогтоол шийдвэрийн биелэлт
- Албан хаагчдыг чадавхжуулсан байдал

ТАВ. ҮР ДҮН.

Хороодыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, хороодын ажилд дэмжлэг үзүүлэн заавар зөвлөгөө өгч зөвлөмж боловсруулан хороодод хүргүүлэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулна.